Эмнэлгийн ажилчдын ажлын байрны стресс, тэдний сэтгэлзүйд нөлөөлөх нь

Д. Баянмөнх

Улсын Хоёрдугаар Төв Эмнэлэг
Цахим хаяг: dbayanmonhk6@gmail.com, Утас: 89500557

Түлхүүр үг:
Стресс
Нөлөөлөх хүчин зүйлс
Сэтгэл зүй

Товч утга: Дэлхий дахинд 400 гаруй төрлийн өвчин эмгэг байдгаас 80 гаруй хувь нь стрессээс үүдэлтэй гэдгийг эрдэмтэн судлаачид тогтоосон байна. Эмнэлгийн нийт ажилчдын стрессийн түвшинг үнэлж, хүний нөөцийн хомсдол болон нэг удаагийн хамгаалах хэрэгсэл тоног төхөөрөмжийн хангалтгүй байдал нь стресс үүсэхэд хэрхэн нөлөөлдгийг, мөн ажлын ачаалал стресс нь эмнэлгийн ажилчдын сэтгэлзүйд хэрхэн нөлөөлж буйг тодорхойлох судалгааг хийлээ. Хүний нөөцийн хомсдол, нэг удаагийн хамгаалах багаж хэрэгсэл болон аппарат тоног төхөөрөмжийн дутагдал нь ажлын байрны стресс үүсэх голлох хүчин зүйлс болдог байна. Ажлын ачаалал их байгаа нь ажлын байрны стресс үүсэх хүчин зүйл болдог бөгөөд эмнэлгийн ажилчдын алдаа гарах эрсдэлд нөлөөлдөг байна.

Үндэслэл: Стресс гэдэг нь бодит болон хийсвэр таагүй зүйлд сэтгэл зүй болон бие махбодь тохиромжтой хариу үйлдэл үзүүлэх чадваргүй болохыг хэлнэ.[1] 1930 онд "стресс гэдэг нэр томъёог хэрэглэж эхэлсэн бөгөөд ажлын байрны стресс гэдэг нь ажлын байранд үүссэн таагүй хүчин зүйлийн улмаас бие махбодь болон сэтгэлзүйд үүсч байгаа хор хөнөөлт байдал юм" гэж тодорхойлсон. Стресс нь санаа алдах, хийсвэр зүйл харах, сэтгэл ханамжгүй байдал, хэт ядрах, дарамтанд байх, уур уцаар, архинд донтох, төвлөрөлт болон ой тогтоолт муудах зэргээр илэрдэг.[2]

Хүн бүр ажил хийх явцдаа ямар нэгэн байдлаар ажлын байрны стрессийг мэдэрдэг бөгөөд энэ нь байгууллагын удирдлага, зохион байгуулалт, нийгмийн халамжийн бодлогоос хамаардаг. Ялангуяа богино хугацаанд ажлыг биелүүлэх болон бэрхшээлтэй ажил үүргийг гүйцэтгэхийн тулд сэтгэлзүйн дарамтанд орж, хэтэрхий ажлын стресс хүндрэхэд энэ бие махбодийн болон сэтгэл санааны хувьд ч хор хөнөөлтэй байдаг.[3]

Ажлын байрны стрессээс хамааран сэтгэл гутрал, сэтгэлийн түгшүүр үүсч, нойргүйдэх, цусны даралт ихсэх, дархлаа суларч эмнэлгийн ажилчдын сэтгэлзүйд нөлөөлж, ажлын эрч хүч буурч, эмнэлгийн алдаа гарах эрсдэл нэмэгдэг.

Иймд эмнэлгийн ажилчдын ажлын байрны стресс үүсэх хүчин зүйлийг тодорхойлж, түүнээс урьдчилан сэргийлэх арга замыг эрэлхийлэх нь уг судалгааг хийх үндэслэл боллоо.

Зорилго: УХТЭ-ийн зарим ажилчдад ажлын байрны стресс үүсэхэд нөлөөлөх хүчин зүйлс, түүний сэтгэлзүйд сөрөг нөлөө үзүүлж буй байдлыг тодорхойлох

Зорилт:

1. Ажлын байран дахь стресс, стресс үүсгэгч хүчин зүйлсийг судлах
2. Ажлын байрны стресс нь сэтгэлзүйд нөлөөлж буй байдалд дүн шинжилгээ хийх


Хэрэглэгдэхүүн, арга аргачлал: Улсын хоёрдугаар төв эмнэлгийн нийт 103 эмч, сувилагч, эмнэлгийн ажилтны ажлын байрны стресст нөлөөлж буй хүчин зүйлийг судлахдаа ОУ-д хүлээн зөвшөөрөгдсөн the work stress questionnaire (WSQ) асуумжийн аргыг ашиглан аналитик судалгааны агшингийн загвараар хийлээ. Судалгааны үр дүнгийн боловсруулалтыг SPSS-17 програмыг ашигласан гүйцэтгэв.

Үр дүн: Судалгаанд нийт 103 ажилтан хамрагдсан бөгөөд албан тушаалаар нь авч үзвэл эмч, эм зүйч 19.4% (20), сувилагч 31.1% (32), үйлчлэгч 15.5% (16), бусад ажилчид 34% (35) хүн байв. Судалгаанд оролцсон хүмүүсийг хүйсээр нь авч үзвэл 18,4% (19) эрэгтэй, 81.6% (84) эмэгтэй байсан бөгөөд насны байдлаар авч үзвэл 25 доош насны 15.5% (16), 26-45 насны 50.5%(52), 46 дээш насны 34% (35) эмнэлгийн ажилтнууд байлаа. Ажилласан жилээр нь авч үзэхэд 0-5 жил 35.9% (37), 6-20 жил 47.6% (49), 21 дээш жил 16.5% (17) хүн тус тус хамрагдлаа.

Нийт судалгаанд оролцогчдын ажлын байран дахь стрессийг түвшингээр нь үнэлсэн. Ховор буюу ер нь хэзээ ч стрессддгүй 15%, бага стрессддэг 28.8%, дунд стрессддэг 32.8%, байнга, маш их стрессддэг 23.4% байгаа нь судалгааны үр дүн ажлын байран дах стресс ажилчдын дунд их байгаа нь ажиглагдаж байна.


Хүний нөөцийн хомсдол болон илүү цагаар ажиллахтай холбоотойгоор ажлын ачаалал их ихэсдэг ажээ.

Бид хүний нөөцийн дутуу байдал нь стресс үүсэхэд хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлоход 13.6% ховор, ер нь хэзээ ч стрессдэггүй, бага стрессдэг 28.2%, дунд стрессдэг 23.3%, байнга, маш их стрессддэг 35% байгаа нь өндөр гэсэн үр дүн судалгаанд ажиглагдлаа (Зураг 1).




Зураг 1. Хүний нөөцийн хомсдол ажлын байрны стресст нөлөөлж буй байдал

Эмнэлгийн ажилчид нэг удаагийн багаж хэрэгсэл болон аппарат тоног төхөөрөмж (маск, малгай, нэг удаагийн халад гэх мэт) хангалтгүй байдал нь стресс үүсэхэд хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлоход 11.7% ховор, бага стрессдэг 20.4%, дунд стрессдэг 35.9%, ер нь хэзээ ч стрессддгүй, 30.1% байнга, маш их стрессддэг нь өндөр гэсэн үр дүн судалгаанд ажиглагдлаа (Зураг 2).



Зураг 2. Эмнэлгийн нэг удаагийн хамгаалах хэрэгслийн дутагдал стресст нөлөөлж буй байдал

Ажлын ачаалал их байх, стресстэй байдал нь эмнэлгийн ажилчдын алдаа (үл тохирол гэх мэт) гаргах эрсдэл үүсэхэд хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлоход 22.3% ховор, бага стрессдэг 42.7%, дунд стрессдэг 26.2%, ер нь хэзээ ч стрессддгүй 8.7% байнга, маш их стрессддэг гэсэн үр дүн судалгаанд ажиглагдлаа. (Зураг 3)



Зураг 3. Ажлын ачаалалтай холбоотой алдаа гарах эрсдлийг тодорхойлсон дүн

Хэлцэмж: Энэхүү судалгааг эмнэлгийн зарим ажилчдын дунд ажлын байрны стресс үүсэх хүчин зүйлийг судалсан бөгөөд улмаар сэтгэлзүйд нөлөөлөх хүчин зүйлийг багасгах арга замыг эрэлхийлэх зорилгоор хийлээ. Мөн нэг удаагийн хамгаалах хувцас хэрэгслийн хангамж дутмаг байдлаас эмнэлгийн ажилчид халдвар авах вий гэсэн айдас, болгоомжлол бий болсноор сэтгэлзүйд шууд нөлөөлж буй нь ажиглагдсан. Түүнчлэн ажлын ачаалал нь эмнэлгийн алдаа гарах эрсдлийг бий болгодог бөгөөд илүү цагаар ажилладаг нь ажилчдын гэр бүлийн таагүй харилцаанд нөлөөлдөг болох нь тогтоогдсон.

Анна Франц нарын судалгаанд эмнэлгийн ажилчдын ажлын байрны стрессийг багасгах арга замыг олсноор тэдний ажлын бүтээмж дээшилж, эмнэлгийн тусламж үйлчилгээг үр дүнтэй үзүүлэх стрессээс үүдэлтэй өвчин эмгэгийг бууруулахад чухал ач холбогдолтой байгаа нь бидний судалгааны үр дүнтэй нийцэж байна.

Тиймээс тухайн чиглэлийн судалгааг бүх шатны эрүүл мэндийн байгууллагад хийж, илүү өргөн цар хүрээнд хамрах шаардлагатай байна.

Дүгнэлт:

1. Хүний нөөцийн хомсдол, нэг удаагийн хамгаалах багаж хэрэгсэл болон аппарат тоног төхөөрөмжийн дутагдал нь ажлын байрны стресс үүсэх голлох хүчин зүйлс болдог байна.
2. Ажлын ачаалал их байгаа нь ажлын байрны стресс үүсэх хүчин зүйл болдог бөгөөд эмнэлгийн ажилчдын алдаа гарах эрсдэлд нөлөөлдөг байна.
3. Эмнэлгийн мэргэжлээр тууштай ажиллуулах, мэргэжлийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, эмнэлгийн тусламжийн чанарыг сайжруулах чиглэлээр стандартын дагуу орон тоогоор хүний нөөцийг нэмэгдүүлж, илүү цагаар ажиллахыг багасгаж ажлын ачааллыг бууруулах, аюулгүй ажиллах нөхцлийг бүрдүүлэх (нэг удаагийн хамгаалах хувцас хэрэгслээр хангах) шаардлагатай байна.

Талархал: Уг судалгааны ажлыг хийж гүйцэтгэхэд гүн туслалцаа үзүүлсэн Уушги судлалын тасгийн хамт олон, Уушги судлалын тасгийн арга зүйч Д. Оюундэлгэр, Сувилахуйн албаны бүрэлдэхүүн, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн халдвар судлаач эмч Дорждэрэм нарт гүн талархал илэрхийлье.

Ном зүй:

1. *Ш.Ичинхорлоо. Судалгааны ажлын үндэс*
2. *Б.Итгэл. Стрессгүй амьдрах нууц*
3. *Л.Энхтуяг. Хувь хүний хөгжил*
4. *Бямбасүрэн. Сэтгэцийн эмгэг судлал. 2017*
5. *Эпидемиологи биостатистик 2014*
6. *Hassard J, Teoh KRH, Visockaite G, Dewe P, Cox T. The cost of work-related stress to society: a systematic review. J Occup Health Psychol. 2018;23(1):1–17. doi: 10.1037/ocp0000069.*
7. *Arbetsmiljöverket (Swedish Work Environment Authority) Work-Related Disorders 2016. Stockholm: Arbetsmiljöverket; 2016. [Google Scholar]*
8. *Falco A, Girardi D, Marcuzzo G, De Carlo A, Bartolucci GB. Work stress and negative affectivity: a multi-method study. Occup Med (Lond) 2013;63(5):341–347. doi: 10.1093/occmed/kqt054. [PubMed] [CrossRef] [Google Scholar]*
9. *Anna Frantz. The Work Stress Questionnaire (WSQ) - reliability and face validity among male workers. 2019 Nov 27;19(1):1580. doi: 10.1186/s12889-019-7940-5.*

Workplace stress and its psychological impact on medical workers

Bayanmunkh.D

State Second Central Hospital
E-mail: dbayanmonhk6@gmail.com, Tel:89500557

Introduction: Researchers estimate that more than 80 percent of the world's 400 diseases are caused by stress. A study was conducted to assess the stress levels of all hospital staff, to determine how lack of human resources and inadequate protective equipment contribute to stress, and how workload stress affects the psychology of medical staff. Lack of human resources, disposable protective equipment and hardware are major factors in workplace stress. High workloads are a source of workplace stress and increase the risk of medical staff making mistakes.

Key words: Workplace stress, workload, medical staff mistake.